



УЛААНБААТАР ТЕАТРААС АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДАД САНАЛ БОЛГОЖ БУЙ  
ТОГЛОЛТЫН ХӨТӨЛБӨР

2024 он



# Melody of Steppes

MONGOLIAN NATIONAL ART CONCERT

EVERYDAY AT 6PM



## МЭНДЧИЛГЭЭ

Дэлхий нийт соёлын хувьд даяаршихын сацуу Монгол Улсад жил бүр айлчлан ирэх жуулчдын тоо эрчимтэй өсөж буй энэ үед Улаанбаатар театраас жуулчдын эрэлт хэрэгцээтэй уялдуулж монголчуудын уламжлалт соёл, зан заншил, нүүдэлчин ахуйг харуулсан, үндэсний агуулгатай мэргэжлийн тайзны уран бүтээлийг турвин аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч та бүхэнд санал болгож байна.

Улаанбаатар театр сүүлийн жилүүдэд хүний нөөцөө нэмж чадварлаг уран бүтээлчдээр уран бүтээлийн багаа тэлж ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Бидний зүгээс бэлтгэсэн тоглолтыг Монгол улсыг зорин ирж буй жуулчдад үзүүлж үндэсний соёл, урлагaa сурталчлан таниулах, театрын чанартай үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн “Улаанбаатар” театрын дарга Ю.Гэрэлбаатар


## БАЙГУУЛАГДСАН ТҮҮХ:

Нийслэлийн Улаанбаатар театр нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 108 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2006 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 487 дугаар захирамжаар үндэсний уламжлалт ардын урлаг болох уртын болон ардын богино дуу, бий биелгээ, цамын бүжиг, хөөмий, үндэсний найрал болон цөөхүүл хөгжмийн ур ухааныг олон нийтэд таниулан сурталчлах, хадгалан хамгаалах, залуу үеийнхэндээ өвлүүлэх зорилготойгоор байгуулагдсан юм.



## БҮТЭЦ:

Өдгөө Улаанбаатар театр нь Уран сайхны зөвлөл (9), Захиргаа анги (10), Хөгжим анги (65), Дуу анги (20), Бүжиг анги (20), Мюзикл анги (8), Тайз анги (14)-иас бүрдсэн нийт 146 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааг явуулж байна.



# *Melody of Steppes*

ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА



Энэхүү хөтөлбөр нь Монголын нэрт зураач Б.Шаравын “Монголын нэг өдөр” бүтээлээс сэдэвлэн гадаадын зочид, жуулчдад зориулан бүтээгдсэн, Монгол ахуй, ёс уламжлалыг уран сайхны хэлбэрээр үзүүлэхэд чиглэгдсэн зохиомжтой бэсрэг хөгжимт жүжгийн хэлбэрийг агуулсан тоглолт юм.

Хөтөлбөрийн онцлог нь тайзнаа өрнөн буй үйл явдалд үзэгчдээ татан оролцуулсан, тэдэнд Монголын ахуй, ёс заншлыг биечлэн таниулсан хийгээд Монгол бүжгийг хамтран бүжиглэх, Монгол идээ цагаагаар бодитоор дайлж амт шимийг биеэр мэдрүүлэхэд оршино.

Тоглолт “Үдэш”, “Өглөө”, “Өдөр” гэсэн 3 хэсгээс бүрдэх бөгөөд тухай тухайн цаг өдрийн Монголын нэг өдөр үргэлжлэх уламжлалт ахуйн заншлыг тусгасан ардын дуу, бүжиг, хөгжим, хөөмий, этник урсгалын бүтээлүүд орсон болно.



Тогтолтонд нийслэлийн “Улаанбаатар театр”-ын 60 мэргэжлийн уран бүтээлч оролцоно.



Бид энэхүү тоглолтоор уран бүтээлийн ерөнхий хэлбэр болох цувраа хэлбэрээс аль болох зайлсхийж, тухайлсан зохиомжтойгоор дэглэн тавьж, гадаадын үзэгчид ба тоглолтод оролцож буй уран бүтээлчдийн хоорондын амьд харьцааг илүү чухалчилсан. Мөн тоглолтын дараа үзэгчид уран бүтээлчидтэй хамт гэрэл зураг авхуулах боломжоор ханган ажиллаж байна.



Танилцуулах тоглолт 2024.05.28-ны өдөр 14:00 цагаас  
Улаанбаатар театрт болно.

Утас: 99675688

Хаяг: СБД, 8-р хороо, бээжингийн гудамж Улаанбаатар театр  
Facebook хуудас: Улаанбаатар театр